

## 2018 оны үйл ажиллагааны тайлан

**Компанийн нэр: Техник импорт ХК**

**Компанийн хаяг: Баянгол дүүрэг, 5-р хороо, Энхтайваны өргөн чөлөө-125**

**Регистрийн дугаар: 2057239**

**Компанийн утас: 70001830**

### 1. Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийн талаар:

Техник импорт ХК нь 2018 онд компанийн “Дүрэм”-ээр олгосон үйл ажиллагааны хүрээнд компанийн ХЭХ-аас баталсан “2018 оны ажлын төлөвлөгөө”-ний дагуу компанийн бизнес үйл ажиллагааг дараахь үндсэн чиглэлээр зохион байгуулж ажиллалаа.  
Үүнд:

1. Хөтөл Цемент Шохой ТӨХК-иас цементийг өөрийн компанидаа болон охин компаниудад нийлүүлж харилцагч аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүмүүсийн захиалгаар худалдан борлуулах
2. ОХУ-аас импортолсон, ОУ-ын чанар, стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн / хөргөгч, угаалгын машин, хөнгөн цагаан хийцийн гэр ахуйн сав, суулга худалдан борлуулах
3. ОХУ-аас импортолсон, ОУ-ын чанар, стандартын шаардлага хангасан авто замын зориулалттай битумийг харилцагч аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүмүүсийн захиалгаар худалдан борлуулах
4. БНХАУ-ын мотоциклийн үйлдвэрээс мотоцикл, мотоциклийн сэлбэг хэрэгслийг импортлон аймаг, хот, хөдөөд болон өөрийн компанийн нэрийн барааны дэлгүүрүүдээр худалдан борлуулах.
5. Өөрийн эзэмшлийн байрыг ажлын байрны зориулалтаар аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүмүүст түрээслүүлэх.

### 2. Компанийн удирдлага, зохион байгуулалтын талаар

Компани нь 2018 онд Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлага, санхүүгийн алба, бизнес хөгжлийн алба, техник хангамж, үйлчилгээний алба, харуул, аж ахуйн үйлчилгээний алба гэсэн бүтээктэй, байнгын ажлын байрны 60 гаруй ажилтантай ажиллалаа.

### 3. 2018 оны үндсэн чиглэлээрх үйл ажиллагааны талаар:

2018 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлаас батлагдсан 2018 оны бизнес төлөвлөгөөний дагуу компаниас удирдлагаас цемент, мотоцикл, битум, ОХУ-ын гэр ахуйн цахилгаан бараа худалдан борлуулах ажлыг амжилттай зохион байгуулж ажилласнаас гадна

Техник импорт ХК үүсэн байгуулагдсаны 60 жилийн түүхт ойг 2018 оны 12-р сарын 08-ний өдөр тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулж компанийн удирдлагаас ойгоо угтаж ажил, хөдөлмөрийн их амжилтаар угтах зорилт тавин энэхүү зорилт, ойн арга хэмжээний хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулж хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажиллаа. Үүнд:

1. Компанийн тугны загвар, эскиз хийх уралдааныг нийт ажилтнуудын дунд зарлан явуулж дүгнэсэн. Тус уралдаанд компанийн ажилтан, менежер Г.Уран-Өлзий, Харуул, аж ахуйн үйлчилгээний албаны дарга Н.Чулуунбаатар нарын бүтээлийг шалгаруулж мөнгөн шагналаар шагнасан.
2. Техник импорт ХК-ийн хөгжлийн түүхийг харуулсан "Жарныг туулсан замнал" нэртэй 60 жилийн ойд зориулсан ном гаргасан.
3. Компанийн хэмжээнд "**Техник импорт ХК-ийн охин компаниудын үйл ажиллагаатай танилцах аян**"-ыг зохион байгуулж явуулсан. Тус аянд Техник импорт компани болон бусад харьяа охин компаниуд бүрэн хамрагдаж оролцсон.
4. Техник импорт ХК болон охин компаниудын бүх ажилчдыг оролцуулан "**Үуланд авирах явган аялал**"-ыг зохион байгуулж явуулсан. Энэхүү явган аялалд компанийн болон бусад охин компаниуд бүрэн хамрагдаж идэвхтэй оролцсон.
5. Компанийн барилгын "**1, 2 давхарт байрлах ариун цэврийн өрөөнүүдийг засварлаж тохижуулах ажил**"-ыг хийсэн. Мөн оффисын төв хаалганы 2 талын талбайд цэцгийн мандал хийж хуучин усан оргилуурыг сэргээн засварлаж бичил цэцэрлэг байгуулах ажлыг хийсэн.
6. Компанийн "**Барилгын дээвэр болон дулааны шугам сүлжээ, компанийн автомашинуудад их засвар болон урсгал засварын ажлуудыг тус тус хийж гүйцэтгэсэн**. Эдгээр ажилд нийтдээ 64 сая төгрөг зарцуулсан.
7. Техник импорт ХК, түүний охин компаниуд, харилцагч аж ахуйн нэгж, байгууллагуудын дунд "**Техник импорт ХК-ийн 60 жилийн ойн нэрэмжит сагсан бөмбөгийн тэмцээн**"-ийг зохион байгуулж явуулсан. Тэмцээнд шалгарсан эхний 3 багийг мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан.
8. Компанийн 60 жилийн ойн арга хэмжээний үеэр 20 ажилтан компанийн шагналаар, 3 хүн төрийн одон медалиар шагнагдсан.
9. **Техник импорт ХК-ийн "60 жилийн ойн хүндэтгэлийн хүлээн авалт"**-нд нийт 400 зочид, төлөөлөгчид хүрэлцэн ирж ойн арга хэмжээнд оролцсон.
10. Компанийн удирдлагаас нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдтэй холбогдуулан дараах үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан. Үүнд.
  - Сар шинийн баярыг тохиолдуулан бүх ажилчдадаа цагаан сарын хэрэгцээнд нь зориулж хонины мах
  - Хүүхдийн баярын өдөрт зориулж компанийн ажилчдын хүүхдийн тоогоор бэлэг
  - Ахмадын баярын өдрөөр компанийн ахмад ажилчдыг угтан авч хоолонд оруулан бэлэг, дурсгалын зүйлс өгөх ажлуудыг зохион байгуулж ажиллаа.

11. Компанийн удирдлагаас ажилчдын өргөдөл, хүсэлтэд үндэслэн 4 150 000 төгрөгийг буцалтгүй тусlamж болгон ажилчдад өгсөн.
12. Компанийн удирдлагаас ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор 46 693 000 төгрөгийг ажилчдад хүүгүй түр зээлээр олгож эргэн төлөлтөнд хяналт тавьж ажиллалаа.
13. Компанийн удирдлагаас Япон улсын Нийгата мужийн НийгатаКубота ХК-тай хамтран монгол улсад хөдөө аж ахуй, газар тариалангийн тоног төхөөрөмж нийлүүлэх чиглэлээр хамтарсан хөрөнгө оруулалттай компани байгуулах төслийн ажлыг амжилттай хэрэгжүүлсэн.
14. Техник импорт ХК болон харьяа охин компаниуд тухайн оны үйл ажиллагааны тайлангаа дараа оны 1 сардаа багтааж бусад компанийн нийт ажилчиддаа тайлagnадаг байх ажлыг 2019 оноос эхлэн тогтмол зохион байгуулж явуулах болсонтой холбогдуулж Техник импорт ХК-ийн удирдлагаас өөрийн болон харьяа компаниудын хариуцсан ажилтнуудад 2018 оны үйл ажиллагаагаа тайлагнахтай холбоотой бэлтгэл ажлыг хангахад анхаарч ажиллах талаар үүрэг, даалгавар өгч ажилласан.

#### 4. Компанийн засаглалыг хэрэгжүүлж байгаа талаар:

##### **Хувьцаа эзэмшигчдийн хурал**

Компани нь “Дүрэм”-дээ “Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна” гэж заасан.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн тухай хуульд заасны дагуу жил бүр санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулдаг.

2018 оны ХЭХ 2018 оны 04 сарын 16-ны өдрийн 15 цагт компанийн “Хурлын танхим”-д хуралдаж дараах асуудлуудыг хувьцаа эзэмшигчдэд танилцуулж хэлэлцүүлсэн.

1. Компанийн 2017 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТҮЗ-аас гаргасан дүгнэлт
2. Компанийн 2017 оны ажлын тайлан
3. Компанийн 2018 оны ажлын төлөвлөгөө
4. 2018 оны ТҮЗ-ын гишүүд, хороодыг сонгох

Уг хуралд саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 98,85% нь оролцсон ба хурлаар хэлэлцсэн асуудлуудын талаар хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал авахад хурлаас гарах шийдвэр, тогтоолын төслийг хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчид дэмжиж 100%-ийн саналаар баталж шийдвэрлэсэн.

“Компанийн тухай хууль”-д заасны дагуу 2018 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТҮЗ-ын Нэр дэвшүүлэх хорооноос ирүүлсэн шаардлагыг хангасан З

хүнийг 2018 оны ТҮЗ-ын хараат бус гишүүнээр, б хүнийг ердийн гишүүнээр тус тус сонгож баталсан. ТҮЗ-ын гишүүдээр сонгогдсон 9 хүн бүгд компанийн засаглалын сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан.

Техник импорт ХК нь жил бүр Хувьцаа эзэмшигчдийн хуралдаа өмнөх оны ногдол ашиг олгосон эсэх талаарх тайлан, ТҮЗ-аас гаргасан ногдол ашгийн талаарх тогтоол, шийдвэрийг танилцуулж тайлагнадаг.

Ногдол ашгийн талаар:

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл 2017, 2018 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ногдол ашгийн талаарх ТҮЗ-ын гаргасан дүгнэлтийг танилцуулж тайлагнасан. 2017 оны 01-р сарын 20-ны өдөр Хорооноос ирүүлсэн 9/210 тоот албан бичгийн 3-р зүйл, 2017 оны 04 сарын 20-ны өдрийн 01/1128 тоот албан бичиг болон 2018 оны 03 сарын 13-ны өдрийн албан бичгийн 3-т заасны дагуу ҮЦТХТ ХХК-тай гэрээ байгуулж 2015 оны ногдол ашгийн үлдэгдлийг компанийн хувьцаа эзэмшигчдэд тараалгахаар шилжүүлсэн ба ҮЦТХТ ХХК-тай байгуулсан гэрээний хуулбар, ҮЦТХТ ХХК-иас ирүүлсэн албан бичгийн эх хувь нийт 3 хуудас материалыг 2018 онд Хороонд хүргүүлж ажилласан.

#### **Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл**

Техник импорт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн удирдлагыг хэрэгжүүлдэг бөгөөд компанийн хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалж, тэднийг төлөөлж компанийн “Дүрэм” болон “ТҮЗ-ын үйл ажиллагааны журам”-аар олгосон эрх, үүргийн хүрээнд компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсан шийдвэр, тогтоолыг хэрэгжүүлэх, компанийн үйл ажиллагааг өрөнхий удирдлагаар хангах, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох, компанийн гүйцэтгэх удирдлагаас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлж ажилладаг.

Төлөөлөн удирдах зөвлөл нь дэргэдээ хороодтой. Үүнд:

#### **ТҮЗ-ын Аудитын хороо**

Аудитын хорооны үйл ажиллагааны үндсэн чиглэл нь Компанийн тухай хууль болон компанийн ТҮЗ-ын үйл ажиллагааны журамд заасан эрх, үүргийн хэмжээнд компанийн нягтлан бодох бүртгэл, аудитын үйл ажиллагаа, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, компанийн дотоод хяналт нягтлан бодох бүртгэлийн сандарт, холбогдох хууль дүрэмд нийцсэн байдал, эрсдлийн удирдлагын бодлого, стратегийг тодорхойлох, эрсдлийн удирдлагын болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих, хараат бус аудитын байгууллагыг сонгох зэрэг үйл ажиллагаанд хяналт тавих замаар Төлөөлөн удирдах зөвлөлд хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөл, бололцоог бүрдүүлэхэд оршдог.

#### **Нэр дэвшүүлэх хороо**

Нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны үндсэн чиглэл нь компанийн ТУЗ-аас ТУЗ-ын гишүүд, Гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлох, сонгон шалгаруулах, ХЭХ-д шууд нэр дэвшүүлэх, ТУЗ-ын гишүүд болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх чиглэлээр ТУЗ-аас чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршдог.

#### **Цалин, урамшууллын хороо**

Цалин, урамшууллын хорооны үйл ажиллагааны үндсэн чиглэл нь компанийн ТУЗ-аас ТУЗ-ын гишүүд, Гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаалтнуудын цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэнд хяналт тавих, цалин, урамшуулал олгох санал боловсруулах, компанийд мөрдөж байгаа ажлын үр дүнтэй холбогдсон компанийн урамшууллын системийн зорилгыг тодорхойлж үр дүнг үнэлэх чиглэлээр ТУЗ-аас чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршдог.

Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, байнгын, мэргэшсэн байдлаар явуулах зорилгоор компанийн үйл ажиллагаатай уялдуулан тодорхой чиглэлээр гаргаж буй хороодын дүгнэлттэй танилцах, хороодын дүгнэлтийг ТУЗ-ын хурлаар хэлэлцүүлж шийдвэр гаргах, шаардлагатай тохиолдолд хороодоос шийдвэр гаргуулах эрхтэйгээр ажилладаг.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын гишүүд хамрах асуудал, чиг үүргийн хүрээний дагуу компанийн гүйцэтгэх удирдлага, албадын дарга нараас өөрсдийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай холбогдох мэдээлэл, баримт материалыг авч судалж боловсруулан ТУЗ-ын хурлаар хэлэлцүүлж гарсан шийдвэрийн дагуу ТУЗ-аас зөвлөмж, үүрэг, даалгаврыг компанийн удирдлагад өгч хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажилладаг.

Төлөөлөн Удирдах Зөвлөл, түүний хороод нь өөрсдийн эрхлэх чиг үүрэгтэй холбогдуулан компанийн бизнес үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, санхүүгийн үйл ажиллагааны явц, байдлын талаар компанийн Гүйцэтгэх удирдлагаас сар тутам тайлан, мэдээлэл авч хянан, холбогдох үүрэг, чиглэл өгч ажилладаг.

2018 оны компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр Д.Баяараа, Э.Батболд, С.Бүжинлхам, Г.Уран-Өлзий, Л.Уртнасан, Т.Тунгалаг, хараат бус гишүүнээр Ж.Баярсайхан, Б.Нарантуяа, Б.Батсайхан, Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Т.Тунгалаг нар сонгогдсон. Компанийн Гүйцэтгэх захирлаар Д.Ганцэцэг ажиллаж байна.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь өнгөрсөн 2018 онд Компанийн тухай хууль, компанийн “Дүрэм”, “ТҮЗ-ын үйл ажиллагааны журам”-аар олгогдсон бүрэн эрхийн хүрээний дагуу

1. 2017 онд ногдол ашиг хуваарилж олгох эсэх тухай
2. 2018 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах тухай
3. Банкнаас зээл авах эрх олгох тухай
4. Компанийн эд хөрөнгийг худалдах тухай

асуудлаар тус тус хуралдаж гишүүдийн дийлэнх олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэн тогтоол гаргаж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажилласан.

2018 онд компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь эрхлэх чиг үүргийн дагуу компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж гүйцэтгэх удирдлагатай хамтран ажилласны үр дүнд компанийн бизнесийн болон төлөвлөгөөт зорилтууд бүрэн биелэгдэх, борлуулалтын орлого өсөх, ашигт ажиллагаа нэмэгдэх, үйл ажиллагаанаас олох ашиг нэмэгдэх нөхцөл боломжуудыг бүрдүүлсэн.

Манай компани нь Хорооноос “Даалгавар өгөх тухай” албан бичиг болон Хөрөнгийн биржээс баталж ирүүлсэн тогтмол мэдээлэл хүргүүлэх хуанлийн дагуу тогтоосон хугацаанд нь компанийн 2018 оны хагас жилийн болон жилийн эцсийн санхүүгийн тайлан, компанийн 2018 оны хагас жилийн үйл ажиллагааны тайлан, 2017 оны ногдол ашиг хуваарилах эсэх тухай болон 2018 оны хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах тухай ТҮЗ-ын хурлын тогтоол, тэмдэглэлийг Монголын Хөрөнгийн Бирж болон Хороонд тус тус хүргүүлж ажилласан ба дээрх компанийн холбоотой тайлан, мэдээллийг компанийн хариуцсан ажилтнаар журамд заасан хугацаанд МХБ-ийн цахим хуудсанд байршуулж олон нийтийг мэдээллээр хангах үүргээ биелүүлж ажилласан.

Техник импорт ХК нь 2018 оны жилийн эцсийн байдлаар 93,9 тэрбум төгрөгийн борлуулалт хийж улсын төсөвт 7,8 тэрбум төгрөгийн татвар төлж 3 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласнаар 2018 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсан бизнесийн болон төлөвлөгөөт зорилтуудыг амжилттай биелүүлж ажиллалаа.

Техник импорт ХК-ийн Гүйцэтгэх захирал



Д. Ганцэцэг